



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

“Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлал”-ыг шинэчлэн батлах, 2014 онд мөрдөх “Хүн амын амьжиргааны доод түвшин”-г тогтоох тухай

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 04-ний болон 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлал”-ын шинэчилсэн найруулгыг I хавсралтаар баталж, мөрдүүлсүгэй.

Хоёр. Батлагдсан аргачлалын дагуу тооцоо хийж, нийтэд мэдээлж ажиллахыг Хүн ам, нийгмийн статистикийн газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

Гурав. “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий 2014 онд мөрдөх хэмжээг II хавсралтаар баталж, 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

Дөрөв. Аргачлалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар /Т.Гантөмөр/-т үүрэг болгосугай.


Тав. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Үндэсний Статистикийн Хорооны даргын 2005 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 1/134 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

Үндэсний статистикийн хорооны даргын  
2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн  
А/4.3. тоот тушаалын II хавсралт



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	146600
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	149600
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	149700
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	144500
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	169000